

Огноо: 2015/03/12

Дугаар 15/03/001

Улаанбаатар хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйл, 64.2 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэх журмын 2,1, 2,3 дахь заалтууд, компанийн дүрмийн 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

**Нэг.** “МОНГОЛИА ДЕВЕЛОПМЕНТ РЕСОРСЕС” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлыг 2015 оны 04 дүгээр сарын 30-ны Пүрэв гарагт 19:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойрог, Пума Импераил зочид буудлын 2-р давхарт байрлах хурлын бага танхимд хуралдуулсугай.

**Хоёр.** Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөр тогтоосугай.

**Гурав.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудын жагсаалтыг тогтоолын Хавсралт 1-ээр баталсугай.

**Дөрөв.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарын загварыг Хавсралт 2-оор баталж, 2015 оны 03 дугаар сарын 16-нд 2-оос доошгүй өдөр тутмын сонин хэвлэл, радио, телевизээр болон МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, мөн 2015 оны 03 дугаар сарын 31-ний дахин зарлах ажлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

**Тав.** Хурлын хэлэлцэх асуудлуудтай холбоотойгоор хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтын жагсаалтыг тогтоолын Хавсралт 3-аар, санал авах хуудасны агуулга, загварыг тогтоолын Хавсралт 4 болон 5-аар, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг тогтоолын Хавсралт 6-аар тус тус баталсугай.

**Зургаа.** Компанийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрөөр буюу 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгосугай.

**Долоо.** Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг хурлаас өмнө бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

**Найм.** Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Компанийн Гүйцэтгэх Захирал Мэндийн Төвшин, комиссын гишүүнээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б. Мягмар нарыг томилсугай.